

БАТШИРЭЭТ СУМ



**БАТШИРЭЭТ СУМЫН АРДЧИЛСАН НАМААС 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020.06.24





БАТШИРЭЭТ СУМЫН АРДЧИЛСАН НАМААС 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

**НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨГ ДЭЭДЛЭГЧ
БАТШИРЭЭТЧҮҮД / Боловсрол, Эрүүл мэнд, Нийгмийн хамгаалал, Соёл, урлаг,
спорт**

- 1.1 Оюунлаг Батширээтчүүд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ
- 1.2 "Эрүүл Батширээтчүүд" хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ
- 1.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадын байгууллагын үйл ажиллагааг дэмжиж ажиллана
- 1.4 Нийгмийн дэмжлэг шаардлагатай өрх болон хүүхдүүдэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.5 Ёохор эвент арга хэмжээг тогтмол зохион байгуулна
- 1.6 Соёлын салбарыг шинэ шатанд гаргаж, соёлын төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттай хангана
- 1.7 Иргэдийн эрүүл идэвхтэй аж төрөх талаар олон нийтийн үүсгэл санаачлагыг дэмжиж, сургалт сурталчилгааг нэмэгдүүлнэ

**ХОЁР. АЖИЛТАЙ ОРЛОГОТОЙ ӨРХ ГЭРИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИГЧ
БАТШИРЭЭТЧҮҮД /өрхийн орлого, ЖДҮ дэмжих, аялал жуулчлал/**

- 2.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Бүтээгч-Батширээтчүүд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж ажиллана
- 2.2 Төсөл хөтөлбөрт хамрагдах иргэдэд тогтмол зөвлөгөө өгөх, зах зээлд нэвтрэхэд нь дэмжлэг үзүүлэх зөвлөх багш менежерийг бэлтгэн ажиллуулснаар бизнесийн тогтвортой өсөлтийг ханган брэндийг бий болгоход анхаарна.
- 2.3 Бренд бүтээгдэхүүнийг патентжуулах ажлыг эхлүүлнэ



- 2.4 Залуус хөгжлийн төвийг менежментийн хувьчлалд оруулах саналыг сумын ИТХ оруулан залуусыг ажлын байраар хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.5 Суманд нэн шаардлагатай мэргэжилтэн бэлтгэхэд ААНэгж, бизнес эрхлэгч иргэд, МСҮТ-тэй хамтран ажиллана.
- 2.6 Рашаан, Ус савлах, цай, самар жимс боловсруулах жижиг үйлдвэрлэл, авто засварын газар, зочид буудлын үйлчилгээг дэмжиж ажиллана
- 2.7 Эко сүү хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ
- 2.8 Сумаас гарч буй хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлыг зах зээлийн менежментэд зохицуулан бий болгоход анхаарах, мах, сүү, сүүн бүтээгдэхүүний жижиглэн худалдаа эко-органик бүтээгдэхүүнийг зах зээлд таниулахад дэмжлэг үзүүлнэ.
- 2.9 Ахуйн үйлчилгээний төвийг төр хувийн хэвшлийн түншлэлээр барих асуудлыг шийдвэрлэнэ
- 2.10 Мах махан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр бий болгоно
- 2.11 Мал нядалгааны газар байгуулах ажлыг дэмжиж ажиллана
- 2.12 ЖДҮДСангаас бизнес эрхлэгч нарыг дэмжих зорилгоор бизнес аялалыг тогтмол зохион байгуулж туршлага солилцох боломжоор хангаж ажиллана
- 2.13 Орон нутгийн онцлогийг шингээсэн аялал жуулчлалын хөтөлбөрийг боловсруулна

ГУРАВ. ИРГЭН БҮРИЙН ОРОЛЦООТОЙ ЭЗЭНТЭЙ БАТШИРЭЭТЧҮҮД /Байгаль орчин, бэлчээр, мал аж ахуй, газар тариалан/

- 3.1 Эко Батширээт хөтөлбөрийн хоёрдугаар үе шатыг хэрэгжүүлнэ
- 3.2 Нөхөрлөлүүдийг бүтээгч-үйлдвэрлэгч болгон чадавхжуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 3.3 Ойн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулна
- 3.4 Мод боловсруулах үйлдвэрлэлийн технологийн шинэчлэлийг хийж хаягдлыг боловсруулахад анхаарч байгаль эколгийн ээлтэй орчинг бүрдүүлнэ
- 3.5 Хайгуулийн болон ашиглалтын лиценз олгохгүй
- 3.6 Байгаль орчин хууль тогтоомж, загас, ан агнуурын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулна
- 3.7 Булаг шандын эх, рашааныг хамгаалах ажлыг хийж ангийн байршил нутагт биотехникийн арга хэмжээ авна
- 3.8 сумын төвийн айл өрхийг био жорлонтой болгох ажлыг эхлүүлнэ
- 3.9 Сумын бэлчээр менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ



3.10 Малын тооноос чанарт шилжих үйл ажиллагааг дэмжиж чинээлэг малчин хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллана.

3.11 Төмс, хүнсний ногоо тариалан эрхлэгчдийг дэмжиж, дотоодын хэрэгцээг бүрэн хангах зорилгоор техник тоног төхөөрөмжийг үе шаттай нэмэгдүүлэх /зоорь, хүлэмж/

ДӨРӨВ. ТӨРӨӨ ДЭЭДЭЛЖ ТҮҮХЭЭ ХҮНДЭТГЭСЭН ХУУЛЬТАЙ БАТШИРЭЭТЧҮҮД /төрийн бодлого, гадаад бодлого/

4.1 Бог малын хээлтүүлгийг мал эмнэлгийн үржлийн аж ахуйн нэгжид төвлөрүүлж үзлэг, ангилалт хийн шаардлага хангасан хээлтүүлэгчээр сүрэг сэлбэх ажлыг тогтмолжуулах

4.2 Төрийн болон төсвийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах, тэдний нийгмийн баталгааг хангахын төлөө ажиллана.

4.3 Хүний нөөцийн бодлогыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх, суманд нэн шаардлагатай байгаа мэргэжилтнээр сум орон нутгаа 100% хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

4.4 Төрөөс гарч байгаа бодлого шийдвэр, үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүртээмжтэй байдлаар хүргэх ажлыг шинэ шатанд гаргана

4.5 Гадаад харилцааг бэхжүүлэх хуучин шейфийн харилцааг сэргээж, шинээр хамтын ажиллагаа тогтооход онцгой анхаарч ажиллана.

4.6 Төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангаж, төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг мөрдлөг болгон ажиллана.

ТАВ. АЮУЛГҮЙ ОРЧИН, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ ӨРНҮҮЛЭГЧ БАТШИРЭЭТЧҮҮД /дэд бүтэц, эрүүл аюулгүй орчин/

5.1 ЕБС-ийн 100 хүүхдийн дотуур байрыг барьж ашиглалтанд оруулна

5.2 Соёлын төвийн барилгыг шинээр барьж ашиглалтанд оруулна

5.3 ЭМТ-ийн өргөтгөлийг барьж ашиглалтанд оруулна

5.4 Онон, Барх голын гүүрний их засварыг хийх

5.5 Тамгын газрын шинэ барилга барих

5.6 Сумын төвийн зам харилцааг шинэчлэх ажлыг үргэлжлүүлж, нэрэмжит гудамжийг сайжруулсан замтай болгоно.



297
174082

5.7 Залуусын хороолол "Ногоон дэнж" хөтөлбөрийг хэрэгжүүлж 10 хүртэлх гэр бүлийг хувийн орон сууцтай болгоно

5.8 Цэцэрлэгт хүрээлэн байгуулах

5.9 Эрүүл хүнс эрүүл хүн аяныг өрнүүлж иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

Батширээт сумын Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг төлөөлж



Намын дарга

Г.Ганцогт

/тэмдэг/

Нарийн бичгийн дарга

Б.Ууганбаяр

2020 оны 06... сарын 24... өдөр